БАЯНХОНГОР АЙМАГ ДАХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2025/010/НА-СТА-ТТЗ**


Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: М.Алтантуяа

Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор: Н.Батчимэг

Утас: 99049866 Цахим хаяг: batchimegn@audit.gov.mn



Баянхонгор

2025 он

Цахим хуудас: www.audit.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ..... 9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ..... 17
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ..... 17
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 18
3.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ..... 18
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ..... 18
3.5.1. Мөнгөн хөрөнгө ..... 19
3.5.2 Авлага ..... 19
3.5.3 Бараа материал ..... 20
3.5.7 Үндсэн хөрөнгө ..... 21
3.5.8 Өр төлбөр ..... 22
3.5.9 Засгийн газрын хувь оролцоо ..... 22
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 22
3.7 Орлогын данс ..... 23
3.8 Зардлын данс ..... 24
3.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ..... 25
АУДИТЫН ТАЙЛАН ..... 27
4.1. Ерөнхий зүйл ..... 27
4.2 Материаллаг байдал ..... 27
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 28
4.4 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 28
4.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 28
4.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 29
4.8 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ..... 29
4.9 Аудитын гол асуудал ..... 29
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ..... 33
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ: ..... 35

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САН..Л ДҮГНЭЛТ

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн хурал |
| НББББB | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг |
| ТЕЗ | Төсвийн ерөнхийлөн захирагч |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| ХХС | Хоршоо хөгжүүлэх сан |
| СТСХ | Санхүү, төрийн сангийн хэлтэс |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2025.03.25 № 2/104

танай____________-ны № _____________ -т

БУУЦАГААН СУМЫН ЗАСАГ
ДАРГА Х.ДАГВАДОРЖ ТАНАА

**Хязгаарлалтай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт алдаа, зөрчил нь гүйцэтгэлийн материаллаг байдлаас давсан.

Бууцагаан сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт сул байгаагаас нийт 545,280.4 мянган төгрөгийн 19 алдаа, зөрчил илэрснээс 31,370.9 мянган төгрөгийн 7 төлбөрийн акт тогтоож, 513,909.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 12 албан шаардлагыг хүргүүлсэн нь өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлөөс 152,104.0 мянган төгрөг буюу 38.7 хувиар өссөн байна.

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогоос хөрөнгө борлуулсны орлого 690.0 мянга, малд ногдох албан татвар 19,767.4 мянга, газрын төлбөрийн орлого 2,042.7 мянга, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 27.9

6425020476

мянга, газрын төлбөр 2,561.1 мянга, ус, рашааны нөөц ашигласны төлбөрийг 110.0 мянган төгрөгөөр тасарсан зэрэг зөрчлүүд илэрлээ.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8 дахь “Сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ”, 23.9 дэх “Сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ”, 41 дүгээр зүйлийн 41.1 дэх “Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ”, 41.2.7 дахь “хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 дахь “Иж бүрэн байх”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийн хангахгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бууцагаан сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2023 оны биелэлтийг 92.7 хувиар үнэлсэн байна.

Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

[illegible] 19·767·4 [illegible] 2·042·7

[illegible] 690·0 152·104·0 [illegible] 38·7 [illegible] ᠃

[illegible] 12 [illegible] 7 [illegible] 513·909·5 [illegible] 545·280·4 [illegible] 19 [illegible] 31·370·9 [illegible] ᠃ [illegible]

[illegible] 2024 [illegible] ᠃

[illegible] ᠃ [illegible]

[illegible]

**[illegible]**

[illegible] ᠃

[illegible] 2024 [illegible] 12 [illegible] 31-[illegible]

[illegible] ᠃

[illegible] 31 [illegible] 2024 [illegible] 12 [illegible] 8 [illegible] 8.9.3 [illegible] 6 [illegible] 6.3.1 · 8 [illegible] 8.1 · [illegible]

**[illegible]**

[illegible] 8 [illegible] [illegible]

[illegible] 2024-09-22 [illegible] 01/200

[illegible]

[illegible] ᠂ [illegible]

[illegible]
[illegible] : procurement. bayankhongor@audit.gov.mn
[illegible] · 64101 · [illegible]: (976) 70442584
[illegible] · [illegible] 1 [illegible] · [illegible]
310 [illegible] · [illegible] 3

00425020290

ᠪᠦᠷᠢᠨ ᠪᠦᠷᠢᠨ ᠢ᠋ ᠬᠠᠮᠤᠷᠤᠭᠰᠠᠨ ᠪᠠᠢᠨ᠎ᠠ ᠃

ᠪᠠᠭ᠎ᠠ ᠰᠤᠷᠭᠠᠭᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠠᠵᠢᠯ

ᠳᠤᠮᠳᠠᠳᠤ ᠶᠢᠨ ᠳᠡᠭᠡᠳᠦ ᠰᠤᠷᠭᠠᠭᠤᠯᠢ

ᠮᠡᠷᠭᠡᠵᠢᠯ ᠦ᠋ᠨ ᠰᠤᠷᠭᠠᠨ ᠬᠦᠮᠦᠵᠢᠯ ᠦ᠋ᠨ ᠠᠵᠢᠯ

2023 ᠣᠨ ᠤ᠋ ... 92.7 ᠬᠤᠪᠢ ...

2024 ᠣᠨ ᠤ᠋ ...

MNS-6817-4:2020 ... 5.2..1.7..2 ... 41.2..7 ... 41.1 ... 41 ... 23.9 ... 23.8 ... 110.0 ᠬᠤᠪᠢ ... 23 ... 2 561.1 ᠬᠤᠪᠢ ... 27.9 ᠬᠤᠪᠢ ...

ᠮᠠᠯ ᠤᠨ ᠡᠮᠨᠡᠯᠭᠡ ᠂ ᠠᠷᠢᠭᠤᠨ ᠴᠡᠪᠡᠷ ᠪᠠᠶᠢᠳᠠᠯ ᠤᠨ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠯᠭ᠎ᠠ ᠶᠢ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠳᠦ ᠶᠠᠮᠠᠷ ᠪᠦᠷ ᠢ ᠪᠡᠶᠡᠯᠡᠭᠦᠯᠦᠨ᠎ᠡ ᠂ ᠰᠠᠶᠢᠳ ᠤᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠬᠤ ᠳᠤ ᠬᠠᠷᠢᠶᠠᠯᠠᠭᠳᠠᠬᠤ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠳᠤ ᠬᠠᠮᠢᠶᠠᠷᠠᠬᠤ ᠪᠠᠷ ᠵᠢᠷᠤᠮᠯᠠᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠦᠨ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠬᠤ ᠪᠣᠯᠤᠨ ᠬᠢᠨᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠦᠯᠬᠦ ᠶᠢᠨ ᠬᠠᠮᠲᠤ ᠪᠠᠶᠢᠨ᠎ᠠ ::

ᠮᠠᠯ ᠤᠨ ᠡᠮᠨᠡᠯᠭᠡ ᠶᠢᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠳᠤ ᠲᠠᠯᠪᠢᠬᠤ ᠰᠢᠭᠠᠷᠳᠠᠯᠭ᠎ᠠ ᠂ ᠬᠦᠰᠡᠯᠲᠡ

ᠮᠠᠯ ᠤᠨ ᠡᠮᠨᠡᠯᠭᠡ ᠶᠢᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠳᠤ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠲᠠᠯᠪᠢᠬᠤ ᠮᠡᠷᠭᠡᠵᠢᠯ ᠦᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠪᠣᠯᠤᠨ ᠮᠡᠷᠭᠡᠵᠢᠯᠲᠡᠨ ᠤ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠯᠭ᠎ᠠ ᠶᠢ ᠰᠠᠶᠢᠵᠢᠷᠠᠭᠤᠯᠬᠤ ᠂ ᠬᠤᠪᠢ ᠬᠦᠮᠦᠨ ᠪᠣᠯᠤᠨ ᠮᠡᠷᠭᠡᠵᠢᠯᠲᠡᠨ ᠦ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠳᠤ ᠬᠠᠮᠲᠤᠷᠠᠨ ᠠᠵᠢᠯᠯᠠᠬᠤ ᠶᠢᠨ ᠬᠠᠮᠲᠤ ᠮᠠᠯ ᠤᠨ ᠡᠮᠨᠡᠯᠭᠡ ᠶᠢᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠂ ᠮᠡᠷᠭᠡᠵᠢᠯᠲᠡᠨ ᠦ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠯᠭ᠎ᠠ ᠶᠢ ᠳᠡᠮᠵᠢᠨ᠎ᠡ ::

ᠮᠠᠯ ᠤᠨ ᠡᠮᠨᠡᠯᠭᠡ ᠶᠢᠨ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠯᠭ᠎ᠠ ᠶᠢ ᠵᠢᠷᠤᠮᠯᠠᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠳᠦ ᠲᠤᠰᠠᠯᠠᠬᠤ ᠪᠣᠯᠤᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠭ᠎ᠠ ᠶᠢ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠬᠤ ᠶᠢᠨ ᠬᠠᠮᠲᠤ ᠮᠡᠷᠭᠡᠵᠢᠯᠲᠡᠨ ᠦ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠳᠤ ᠲᠤᠰᠠᠯᠠᠬᠤ ᠮᠡᠷᠭᠡᠵᠢᠯ ᠦᠨ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠭ᠎ᠠ ᠪᠠᠨ ᠪᠡᠶᠡᠯᠡᠭᠦᠯᠬᠦ ᠶᠢᠨ ᠲᠤᠯᠠ ᠬᠦᠷᠡᠯᠴᠡᠭᠡ ᠳᠤ ᠰᠠᠶᠢᠵᠢᠷᠠᠭᠤᠯᠬᠤ ᠪᠣᠯᠤᠨ ᠮᠡᠷᠭᠡᠵᠢᠯᠲᠡᠨ ᠦ ᠮᠡᠳᠡᠯᠭᠡ ᠶᠢ ᠳᠡᠭᠡᠭᠰᠢᠯᠡᠭᠦᠯᠬᠦ ᠶᠢᠨ ᠲᠤᠯᠠ ᠰᠤᠷᠭᠠᠯᠲᠠ ᠶᠢ ᠵᠣᠬᠢᠶᠠᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠨ᠎ᠠ ::

ᠮᠠᠯ ᠤᠨ ᠡᠮᠨᠡᠯᠭᠡ ᠶᠢᠨ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠯᠭ᠎ᠠ ᠶᠢ ᠵᠢᠷᠤᠮᠯᠠᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠳᠦ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠪᠠᠶᠢᠳᠠᠯ ᠢ ᠬᠢᠨᠠᠨ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠬᠤ ᠶᠢᠨ ᠬᠠᠮᠲᠤ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠪᠠᠶᠢᠳᠠᠯ ᠤᠨ ᠲᠠᠶᠢᠯᠤᠨ ᠬᠢᠨᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠦᠯᠬᠦ ᠶᠢᠨ ᠬᠠᠮᠲᠤ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠳᠤ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠬᠤ ᠂ ᠲᠠᠶᠢᠯᠤᠨ ᠲᠤᠰᠠᠯᠠᠬᠤ ᠪᠣᠯᠤᠨ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠦᠯᠲᠡ ᠳᠦ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠲᠠᠯᠪᠢᠨ᠎ᠠ ::

ᠪᠣᠯᠭᠠᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠦᠯᠲᠡ ᠶᠢᠨ ᠲᠠᠶᠢᠯᠤᠨ ::

ᠰᠠᠶᠢᠳ ᠂ ᠰᠠᠶᠢᠳ ᠤᠨ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠭ᠎ᠠ ........ ᠪ. ᠪᠠᠲᠤᠮᠥᠩᠬᠡ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (мянган төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **902,786.57** | **896,851.82** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **507,382.43** | **413,725.76** |
| **31200** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **507,382.43** | **413,725.76** |
| **31210** | **Төгрөг** | **507,382.43** | **413,725.76** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 507,382.43 | 413,725.76 |
| **33** | **АВЛАГА** | **252,453.44** | **228,495.29** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 742.38 | 41.05 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 10.00 | 10.00 |
| **33500** | **Бусад авлага** | **36,180.00** | **36,180.00** |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | 36,180.00 | 36,180.00 |
| **33600** | **Зээлийн авлага** | **215,521.06** | **192,264.24** |
| **33610** | **Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага** | **215,521.06** | **192,264.24** |
| 33612 | Хувь хүмүүст олгосон зээл | 215,521.06 | 192,264.24 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **142,950.70** | **254,630.78** |
| **35100** | **Түүхий эд материал** | **13,695.00** | **41,767.00** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 13,695.00 | 41,767.00 |
| **35400** | **Хангамжийн материал** | **88,678.32** | **172,286.39** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 4,417.34 | 4,776.64 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 300.00 | 840.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 8,892.00 | 20,042.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 75,068.98 | 146,627.76 |
| 35600 | Мал амьтад | 40,577.38 | 40,577.38 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,105,643.59** | **2,187,880.93** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **2,105,643.59** | **2,187,880.93** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **2,087,643.59** | **2,169,880.93** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 4,788,862.18 | 4,828,862.18 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -3,102,316.21 | -3,315,198.57 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 277,350.50 | 317,741.11 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -226,417.85 | -237,819.72 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 233,191.10 | 233,383.05 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -152,114.72 | -82,333.40 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 121,943.15 | 104,486.62 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -91,153.56 | -53,379.61 |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 27,000.00 | 27,000.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | 0.00 | -1,350.00 |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 7,000.00 | 7,000.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 277,874.72 | 439,890.72 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -73,575.71 | -98,401.46 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **18,000.00** | **18,000.00** |
| 39301 | Програм хангамж | 13,978.00 | 13,978.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -13,978.00 | -13,978.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 18,000.00 | 18,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,008,430.16** | **3,084,732.75** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **2,143.36** | **4,191.24** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **2,143.36** | **4,191.24** |
| **41300** | **Өглөг** | **2,143.36** | **4,191.24** |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 0.00 | 1,166.25 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 1,643.36 | 2,150.00 |
| **41360** | **Бусад өглөг** | **500.00** | **874.99** |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 500.00 | 874.99 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,006,286.81** | **3,080,541.51** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **3,006,286.81** | **3,080,541.51** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 537,862.77 | 537,862.77 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 537,862.77 | 537,862.77 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **2,049,096.39** | **2,123,531.11** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,877,116.98 | 2,048,558.52 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 171,979.41 | 74,972.59 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 419,327.64 | 419,147.63 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,008,430.16** | **3,084,732.75** |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (мянган төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **4,257,606.93** | **3,063,903.89** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **637,385.33** | **917,734.83** |
| **110** | **Орлогын албан татвар** | **326,220.79** | **646,607.59** |
| **1100** | **Хувь хүний орлогын албан татвар** | **326,220.79** | **646,607.59** |
| 110001 | Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх | 250,234.76 | 418,679.22 |
| 110002 | Үйл ажиллагааны орлого | 25,919.64 | 168,488.01 |
| 110003 | Хөрөнгийн орлого | 46,258.19 | 57,130.36 |
| 110004 | Хөрөнгө борлуулсны орлого | 3,808.20 | 2,310.00 |
| **113** | **Хөрөнгийн албан татвар** | **68,237.35** | **101,559.47** |
| 113001 | Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | 1,484.45 | 2,011.86 |
| 113002 | Бууны албан татвар | 2,280.00 | 3,120.00 |
| 113004 | Малд ногдуулах албан татвар | 64,472.90 | 96,427.61 |
| **118** | **Бусад татвар, төлбөр, хураамж** | **242,927.19** | **169,567.77** |
| **1180** | **Бусад нийтлэг төлбөр, хураамж** | **32,164.56** | **32,008.22** |
| 118001 | Улсын тэмдэгтийн хураамж | 10,916.03 | 10,821.14 |
| 118006 | Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | 0.00 | 472.07 |
| 118009 | Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 21,248.53 | 20,715.00 |
| **1181** | **Газрын төлбөр** | **6,907.23** | **5,438.88** |
| 118101 | Газрын төлбөр | 6,907.23 | 3,938.88 |
| 118102 | Дуудлага худалдаа | 0.00 | 1,500.00 |
| **1182** | **Байгалийн нөөц ашигласны төлбөр** | **203,716.15** | **132,120.68** |
| 118202 | Ан амьтны нөөц ашигласны төлбөр | 203,008.88 | 118,890.70 |
| 118203 | Ус, рашааны нөөц ашигласны төлбөр | 707.28 | 13,229.98 |
| **1183** | **Бусад татвар** | **139.25** | **0.00** |
| 118301 | Бусад татвар | 139.25 | 0.00 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **442,948.77** | **596,002.62** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **442,948.77** | **596,002.62** |
| 120003 | Торгуулийн орлого | 83,680.88 | 138,279.00 |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **12,187.11** | **37,109.13** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 10,717.35 | 12,811.80 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,469.76 | 24,297.33 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 268,027.19 | 317,570.71 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 79,053.58 | 103,043.78 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **3,177,272.83** | **1,550,166.43** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **34,641.33** | **64,807.23** |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 25,033.31 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 34,641.33 | 39,773.91 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **3,142,631.51** | **1,485,075.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,617,126.00 | 0.00 |
| 132003 | Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/ | 84,118.41 | 0.00 |
| 132006 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/ | 1,037,166.80 | 1,145,307.40 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 404,220.30 | 339,767.60 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | **0.00** | **284.21** |
| 133002 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0.00 | 284.21 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **4,078,665.61** | **2,981,839.63** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **4,078,665.61** | **2,981,839.63** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,373,409.04** | **2,922,426.70** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **482,397.76** | **785,994.97** |
| 210101 | Үндсэн цалин | 369,910.47 | 475,392.03 |
| 210102 | Нэмэгдэл | 112,487.29 | 253,855.08 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.00 | 25,700.80 |
| 210104 | Урамшуулал | 0.00 | 20,701.10 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 0.00 | 10,345.96 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **60,116.37** | **96,864.09** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 40,892.41 | 65,569.48 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,811.03 | 7,679.46 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,848.76 | 4,476.18 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 957.40 | 3,775.56 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,606.76 | 15,363.41 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **45,517.98** | **833,499.61** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 12,420.52 | 60,300.63 |
| 210302 | Түлш, халаалт | 32,597.66 | 764,662.68 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 499.80 | 8,536.30 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **156,804.50** | **108,738.40** |
| 210401 | Бичиг хэрэг | 4,292.83 | 5,285.13 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 71,432.34 | 71,808.32 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,759.80 | 1,970.60 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 9,936.96 | 28,874.95 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,436.55 | 799.40 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 59,946.02 | 0.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **11,958.20** | **21,170.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0.00 | 320.00 |
| 210604 | Урсгал засвар | 11,958.20 | 20,850.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **6,540.00** | **10,365.60** |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,540.00 | 10,365.60 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,200,593.44** | **667,650.03** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,200,408.14 | 661,960.18 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 0.00 | 800.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 0.00 | 27.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 0.00 | 60.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 185.30 | 3,853.12 |
| 210807 | Газрын төлбөр | 0.00 | 650.23 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 0.00 | 299.50 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **409,480.80** | **398,144.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 102,053.42 | 92,068.20 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 0.00 | 1,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 307,427.38 | 305,075.80 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,705,256.57** | **59,412.93** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **3,728.00** | **59,412.88** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 500.00 | 0.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 0.00 | 34,629.71 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 0.00 | 22,683.17 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,228.00 | 2,100.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **1,701,528.57** | **0.05** |
| 213401 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага | 1,617,126.00 | 0.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 84,118.41 | 0.00 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 284.16 | 0.05 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **178,941.32** | **82,064.26** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **6,961.92** | **7,091.67** |
| 225010 | Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө | 6,961.92 | 7,091.67 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **171,979.41** | **74,972.59** |

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (мянган төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **537,862.77** | **419,363.12** | **1,840,901.51** | **2,798,127.40** |
| **2** | **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | **0.00** | **0.00** | **36,215.47** | **36,215.47** |
| **3** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **537,862.77** | **419,363.12** | **1,877,116.98** | **2,834,342.87** |
| **4** | **Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт** | **0.00** | **-35.47** | **0.00** | **-35.47** |
| **9** | **Тайлант үеийн үр дүн** | **0.00** | **0.00** | **171,979.41** | **171,979.41** |
| **10** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **537,862.77** | **419,327.64** | **2,049,096.39** | **3,006,286.81** |
| **11** | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **537,862.77** | **419,327.64** | **2,049,096.39** | **3,006,286.81** |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | -537.87 | -537.87 |
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **537,862.77** | **419,327.64** | **2,048,558.52** | **3,005,748.93** |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0.00 | -180.01 | 0.00 | -180.01 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 74,972.59 | 74,972.59 |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **20** | **2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **537,862.77** | **419,147.63** | **2,123,531.11** | **3,080,541.51** |

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (мянган төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **3,966,074.90** | **2,666,546.22** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **637,385.33** | **917,734.83** |
| **110** | **Орлогын албан татвар** | **326,220.79** | **646,607.59** |
| **1100** | **Хувь хүний орлогын албан татвар** | **326,220.79** | **646,607.59** |
| 110001 | Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх | 250,234.76 | 418,679.22 |
| 110002 | Үйл ажиллагааны орлого | 25,919.64 | 168,488.01 |
| 110003 | Хөрөнгийн орлого | 46,258.19 | 57,130.36 |
| 110004 | Хөрөнгө борлуулсны орлого | 3,808.20 | 2,310.00 |
| **113** | **Хөрөнгийн албан татвар** | **68,237.35** | **101,559.47** |
| 113001 | Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | 1,484.45 | 2,011.86 |
| 113002 | Бууны албан татвар | 2,280.00 | 3,120.00 |
| 113004 | Малд ногдуулах албан татвар | 64,472.90 | 96,427.61 |
| **118** | **Бусад татвар, төлбөр, хураамж** | **242,927.19** | **169,567.77** |
| **1180** | **Бусад нийтлэг төлбөр, хураамж** | **32,164.56** | **32,008.22** |
| 118001 | Улсын тэмдэгтийн хураамж | 10,916.03 | 10,821.14 |
| 118006 | Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | 0.00 | 472.07 |
| 118009 | Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 21,248.53 | 20,715.00 |
| **1181** | **Газрын төлбөр** | **6,907.23** | **5,438.88** |
| 118101 | Газрын төлбөр | 6,907.23 | 3,938.88 |
| 118102 | Дуудлага худалдаа | 0.00 | 1,500.00 |
| **1182** | **Байгалийн нөөц ашигласны төлбөр** | **203,716.15** | **132,120.68** |
| 118202 | Ан амьтны нөөц ашигласны төлбөр | 203,008.88 | 118,890.70 |
| 118203 | Ус, рашааны нөөц ашигласны төлбөр | 707.28 | 13,229.98 |
| **1183** | **Бусад татвар** | **139.25** | **0.00** |
| 118301 | Бусад татвар | 139.25 | 0.00 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **151,416.73** | **198,644.96** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **151,416.73** | **198,644.96** |
| 120003 | Торгуулийн орлого | 83,680.88 | 138,279.00 |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **67,735.85** | **60,365.96** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 67,521.09 | 59,024.36 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 214.76 | 1,341.60 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **3,177,272.83** | **1,550,166.43** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **34,641.33** | **64,807.23** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,300.00 | 25,033.31 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 33,341.33 | 39,773.91 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **3,142,631.51** | **1,485,075.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,617,126.00 | 0.00 |
| 132003 | Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/ | 84,118.41 | 0.00 |
| 132006 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/ | 1,037,166.80 | 1,145,307.40 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 404,220.30 | 339,767.60 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | **0.00** | **284.21** |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 133002 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0.00 | 284.21 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **3,276,285.29** | **2,127,390.32** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,276,285.29** | **2,127,390.32** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,570,428.72** | **2,068,005.49** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **481,945.12** | **784,600.99** |
| 210101 | Үндсэн цалин | 342,491.77 | 451,975.60 |
| 210102 | Нэмэгдэл | 139,453.35 | 284,135.37 |
| 210104 | Урамшуулал | 0.00 | 32,490.02 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 0.00 | 16,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **60,224.02** | **98,042.09** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 40,965.56 | 66,697.96 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,819.63 | 7,850.39 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,855.60 | 3,937.40 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 959.16 | 3,880.79 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,624.06 | 15,675.54 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **663,834.78** | **834,039.61** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 47,053.84 | 61,124.65 |
| 210302 | Түлш, халаалт | 607,093.24 | 764,078.66 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,687.70 | 8,836.30 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **89,319.94** | **95,706.47** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,690.90 | 4,865.75 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 71,118.09 | 58,599.42 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,238.95 | 1,803.30 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 11,672.00 | 29,598.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 600.00 | 840.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **9,700.00** | **22,729.30** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0.00 | 1,729.30 |
| 210604 | Урсгал засвар | 9,700.00 | 21,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **7,543.00** | **7,903.70** |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,543.00 | 7,903.70 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **83,182.24** | **127,347.33** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 78,533.24 | 121,647.60 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500.00 | 800.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 27.00 | 27.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 60.00 | 60.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,762.00 | 3,863.00 |
| 210807 | Газрын төлбөр | 0.00 | 650.23 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 300.00 | 299.50 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **174,679.63** | **97,636.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 168,679.65 | 95,636.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,999.98 | 2,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,705,856.57** | **59,384.83** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **4,328.00** | **59,384.78** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 0.00 | 34,629.71 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 0.00 | 22,655.07 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,328.00 | 2,100.00 |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **1,701,528.57** | **0.05** |
| 213401 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага | 1,617,126.00 | 0.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 84,118.41 | 0.00 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 284.16 | 0.05 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **689,789.61** | **539,155.90** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **504,207.88** | **632,812.58** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **504,207.88** | **632,812.58** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **504,207.88** | **632,812.58** |
| 220001 | Барилга байгууламж | 494,707.98 | 555,978.48 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 9,499.90 | 76,834.10 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-504,207.88** | **-632,812.58** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **185,581.73** | **-93,656.67** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 321,800.71 | 507,382.43 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 507,382.43 | 413,725.76 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| II | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,876,160.50** | **2,695,395.67** | **180.76** | **93.7** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,255,795.00** | **2,139,417.19** | **116.38** | **94.8** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,219,002.70** | **2,102,687.48** | **116.32** | **94.8** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **787,476.30** | **784,600.99** | **2.88** | **99.6** |
| 210101 | Үндсэн цалин | 451,975.60 | 451,975.60 | 0.00 | 100.0 |
| 210102 | Нэмэгдэл | 284,606.20 | 284,135.37 | 0.47 | 99.8 |
| 210104 | Урамшуулал | 34,894.50 | 32,490.02 | 2.40 | 93.1 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 16,000.00 | 16,000.00 | 0.00 | 100.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **98,434.60** | **98,042.09** | **0.39** | **99.6** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 66,935.50 | 66,697.96 | 0.24 | 99.6 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,874.70 | 7,850.39 | 0.02 | 99.7 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,937.40 | 3,937.40 | 0.00 | 100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,937.40 | 3,880.79 | 0.06 | 98.6 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,749.60 | 15,675.54 | 0.07 | 99.5 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **845,317.90** | **834,039.61** | **11.28** | **98.7** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 69,950.00 | 61,124.65 | 8.83 | 87.4 |
| 210302 | Түлш, халаалт | 766,197.90 | 764,078.66 | 2.12 | 99.7 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,170.00 | 8,836.30 | 0.33 | 96.4 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **101,100.80** | **95,706.47** | **5.39** | **94.7** |
| 210401 | Бичиг хэрэг | 10,192.50 | 4,865.75 | 5.33 | 47.7 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 58,600.00 | 58,599.42 | 0.00 | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,870.30 | 1,803.30 | 0.07 | 96.4 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 29,598.00 | 29,598.00 | 0.00 | 100.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 840.00 | 840.00 | 0.00 | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **52,500.00** | **52,483.40** | **0.02** | **100.0** |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 21,500.00 | 21,493.65 | 0.01 | 100.0 |
| 210602 | Тавилга | 10,000.00 | 9,989.75 | 0.01 | 99.9 |
| 210604 | Урсгал засвар | 21,000.00 | 21,000.00 | 0.00 | 100.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **7,967.70** | **7,903.70** | **0.06** | **99.2** |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,967.70 | 7,903.70 | 0.06 | 99.2 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **131,705.40** | **115,447.38** | **16.26** | **87.7** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 125,954.40 | 109,747.64 | 16.21 | 87.1 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 800.00 | 800.00 | 0.00 | 100.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 27.00 | 27.00 | 0.00 | 100.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 60.00 | 60.00 | 0.00 | 100.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,864.00 | 3,863.00 | 0.00 | 100.0 |
| 210807 | Газрын төлбөр | 700.00 | 650.23 | 0.05 | 92.9 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 300.00 | 299.50 | 0.00 | 99.8 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **194,500.00** | **114,463.85** | **80.04** | **58.9** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 192,500.00 | 112,463.85 | 80.04 | 58.4 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,000.00 | 2,000.00 | 0.00 | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **36,792.30** | **36,729.71** | **0.06** | **99.8** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **36,792.30** | **36,729.71** | **0.06** | **99.8** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 34,692.30 | 34,629.71 | 0.06 | 99.8 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,100.00 | 2,100.00 | 0.00 | 100.0 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **620,365.50** | **555,978.48** | **64.39** | **89.6** |
| 220001 | Барилга байгууламж | 620,365.50 | 555,978.48 | 64.39 | 89.6 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **2,876,160.50** | **2,736,141.16** | **140.02** | **95.1** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **360,025.40** | **0.00** | **360.03** | **0.0** |
| 310004 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | 360,025.40 | 0.00 | 360.03 | 0.0 |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **2,386,219.60** | **2,675,775.20** | **-289.56** | **112.1** |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 2,386,219.60 | 2,336,007.60 | 50.21 | 97.9 |
| 320002 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 0.00 | 339,767.60 | -339.77 | |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **129,915.50** | **60,365.96** | **69.55** | **46.5** |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 61,000.00 | 59,024.36 | 1.98 | 96.8 |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000.00 | 1,341.60 | -0.34 | 134.2 |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 67,915.50 | 0.00 | 67.92 | 0.0 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 85,172.62 | -85.17 | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 125,918.11 | -125.92 | |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **60.00** | **60.00** | **0.00** | **100.0** |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **2.00** | **2.00** | **0.00** | **100.0** |
| 610001 | Төсвийн байгууллага | 2.00 | 2.00 | 0.00 | 100.0 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **29.00** | **29.00** | **0.00** | **100.0** |
| 620001 | Удирдах ажилтан | 11.00 | 11.00 | 0.00 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 15.00 | 15.00 | 0.00 | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 3.00 | 3.00 | 0.00 | 100.0 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн тайлан (мянган төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | ТЗ цэвэр дүн |
|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **64,807.23** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **64,807.23** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **42,152.11** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **38,899.95** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 38,899.95 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **3,252.15** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,252.15 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **22,655.12** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **22,655.07** |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 22,655.07 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **0.05** |
| 213405 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 0.05 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **64,807.23** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **64,807.23** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 25,033.31 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 39,773.91 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Бууцагаан сум нь "Төрийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх, иргэдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, ардчилал шударга ёсыг тогтоох, хууль дээдлэх төрийн үйл ажиллагаа, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, олон талт арга хэмжээг хэрэгжүүлэх, ажил үйлчилгээг хөнгөн шуурхай жигд хүртээмжтэй явуулах, төсөв санхүүгийн хэмжээг тодорхойлох, эцсийн үр дүнг үнэлж дүгнэх, нийгмийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх" гэсэн эрхэм зорилго дэвшүүлэн дараах зорилтыг тавин ажиллажээ. Үүнд:

- Хөдөө аж ахуйг хөгжүүлэх
- Газар тариаланг хөгжүүлэх
- Нийтийн аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх
- Байгаль хамгаалах хөтөлбөр
- Сумын эдийн засаг, нийгмийн үндсэн чиглэлийг хөгжүүлэх
- Төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сурталчлах, сургалт сурталчилгаа
- Сумын засан даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх
- Монгол Улсын Засгийн газраас боловсрол, соёл, эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх
- Иргэдийн оролцоог хангах

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь Бууцагаан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бууцагаан сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь 2018 онд аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсээс гаргасан “Төсөвт байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа НБББ нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, ТОЛИЛУУЛГАД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТҮҮД

Бууцагаан сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ийн дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 76,302.6 мянган төгрөгөөр буюу 2.5 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

(мянган төгрөгөөр)

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 902,786.5 | 896,851.9 | (5,934.6) |
| Мөнгөн хөрөнгө | 507,382.4 | 413,725.8 | (93,656.6) |
| Авлага | 252,453.4 | 228,495.3 | (23,958.1) |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| Бараа материал | 142,950.7 | 254,630.8 | 111,680.1 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 2,105,643.7 | 2,187,880.9 | 82,237.2 |
| Үндсэн хөрөнгө | 5,765,199.8 | 5,990,341.7 | 225,141.9 |
| Хуримтлагдсан элэгдэл | (3,659,556.1) | (3,802,460.8) | (142,904.7) |
| **Нийт хөрөнгө** | **3,008,430.2** | **3,084,732.8** | **76,302.6** |
| Өр төлбөр | 2,143.4 | 4,191.2 | 2,047.9 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 3,006,286.8 | 3,080,541.5 | 74,254.7 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **3,008,430.2** | **3,084,732.8** | **76,302.6** |

### 3.5.1. Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 507,382.4 мянган төгрөг байсан бөгөөд эцсийн үлдэгдэл 413,725.8 мянган төгрөг болж 93,656.6 мянган төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт № 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл* */мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Касст байгаа бэлэн мөнгө | 0 | 0 | 0 | 0 |
| Төрийн санд байгаа бэлэн мөнгө | 507,382.4 | 413,725.8 | -93,656.6 | 100% |
| Орон нутгийн ерөнхий орлого | 422,209.8 | 287,807.7 | -134,402.1 | 69.6% |
| Орон нутгийн хөгжлийн сан | 59,897.8 | 54,430.7 | -5,467.1 | 13.2% |
| Хоршоо хөгжүүлэх сан | 25,274.8 | 71,487.4 | 46,212.6 | 17.3% |
| Замд яваа мөнгөн хөрөнгө | 0 | 0 | 0 | |
| Хадгаламж | 0 | 0 | 0 | |
| **Дүн** | **507,382.4** | **413,725.8** | **-93,656.6** | **100%** |

*Эх сурвалж: Бууцагаан сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 413,725.8 мянган төгрөг нь орон нутгийн Ерөнхий орлогын дансны үлдэгдэл 287,807.7 мянга, Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд 54,430.7 мянга, Сум хөгжүүлэх сангийн дансанд 71,487.4 мянган төгрөг тус тус байршиж байна.

### 3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 252,453.4 мянган төгрөг байсан ба эцсийн үлдэгдэл 228,495.3 мянган төгрөг болж 23,958.1 мянган төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт № 3. Авлагын үлдэгдэл* */ мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Ажиллагсадтай холбогдсон авлага | 742.4 | 41.1 | (701.3) |
| Төлбөртэй үйлчилгээний авлага | 10.0 | 10.0 | - |
| Хувь хүмүүсээс авах авлага | 36,180.0 | 36,180.0 | - |
| Хувь хүмүүст олгосон зээл | 215,521.0 | 192,264.2 | (23,256.8) |
| **Дүн** | 252,453.4 | 228,495.3 | -23,958.1 |

Эх сурвалж: *Бууцагаан сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Нийт авлагын 84.1 хувь буюу 192,264.2 мянган төгрөг нь хоршоо хөгжүүлэх сангийн сангийн авлага, 15.8 хувь буюу 36,180.0 мянган төгрөг нь хувь хүмүүсээс авах авлага байна.

*Хүснэгт № 4. Авлагын үлдэгдэл байгууллагаар* */мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Засаг даргын Тамгын газар | 36,214.5 | 36,231.1 | 16.6 | 15.9 |
| ИТХ | 717.9 | | -717.9 | 0.0 |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 005 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | |
|---|---|---|---|---|
| СХС | 215,521.0 | 192,264.2 | -23,256.8 | 84.1 |
| **НИЙТ ДҮН** | **252,453.4** | **228,495.3** | **-23,958.1** | **100.00** |

*Эх сурвалж: Бууцагаан сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд өмнөх оноос хоршоо хөгжүүлэх сангийн авлага 23,256.8 мянган төгрөгөөр буурсан, ЗДТГ-ын авлага 16.6 мянган төгрөгөөр өссөн байна.

### 3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 142,950.7 мянган төгрөг байсан ба эцсийн үлдэгдэл 254,630.8 мянган төгрөг болж, 111,680.1 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 5. Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Тусгай зориулалтын материал | 13,695.0 | 41,767.0 | 28,072.0 |
| Бичиг хэргийн материал | 4,417.3 | 4,776.6 | 359.3 |
| Түлш, шатах тослох материал | 300.0 | 840.0 | 540.0 |
| Барилгын засварын материал | 8,892.0 | 20,042.0 | 11,150.0 |
| Бусад хангамжийн материал | 75,069.0 | 146,627.8 | 71,558.8 |
| Мал амьтад | 40,577.4 | 40,577.4 | 0.0 |
| **Дүн** | **142,950.7** | **254,630.8** | **111,680.1** |

*Эх сурвалж: Бууцагаан сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Бараа материалын дансны үлдэгдэл 254,630.8 мянган төгрөг болж 111,680.1 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 6. Бараа материалын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дунд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| ИТХ | 1,852.9 | 3,262.9 | 1,410.0 | 1.3 |
| ЗДТГ | 141,097.8 | 250,827.9 | 109,730.1 | 98.5 |
| Бага сургууль | | 540.0 | 540.0 | 0.2 |
| **НИЙТ ДҮН** | **142,950.7** | **254,630.8** | **111,680.1** | **100.0** |

*Эх сурвалж: Бууцагаан сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд нийт нэмэгдсэн 342,362.4 мянган төгрөгийн бараа материалаас 239,318.6 мянган төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр, 103,043.8 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлэн авсан байна. Мөн нийт хасагдсан 230,682.3 мянган төгрөгийн бараа материалаас 230,682.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

*Хүснэгт № 7. Бараа материалын орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/*

| Нэмэгдсэн | 342,362.4 | Хасагдсан | 230,682.3 |
|---|---|---|---|
| Худалдан авсан | 239,318.6 | Худалдсан, зарцуулсан | 230,682.3 |
| Хандиваар | | шилжүүлсэн | |
| Шилжүүлсэн авсан | 103,043.8 | | |

*Эх сурвалж: Бууцагаан сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### 3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 5,738,199.7 мянган төгрөг байсан ба эцсийн үлдэгдэл 5,963,778.3 мянган төгрөг болж 225,578.6 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| БИЕТ ХӨРӨНГӨ | 5,706,221.7 | 5,931,800.3 | 225,578.6 | 99.5 |
| Барилга байгууламж, орон сууц | 4,788,862.2 | 4,828,862.2 | 40,000.0 | 81.0 |
| Тээврийн хэрэгсэл | 277,350.5 | 317,741.1 | 40,390.6 | 5.3 |
| Машин тоног төхөөрөмж | 233,191.1 | 233,819.7 | 628.6 | 3.9 |
| Тавилга эд хогшил | 121,943.2 | 104,486.6 | -17,456.6 | 1.8 |
| Зам гүүрийн байгууламж | 27,000.0 | 27,000.0 | 0.0 | 0.5 |
| Түүх соёлын дурсгалт зүйл | 7,000.0 | 7,000.0 | 0.0 | 0.1 |
| Бусад үндсэн хөрөнгө | 277,874.7 | 439,890.7 | 162,016.0 | 7.4 |
| **БИЕТ БУС ХӨРӨНГӨ** | 31,978.0 | 31,978.0 | 0.0 | 0.5 |
| Программ хангамж | 13,978.0 | 13,978.0 | 0.0 | 0.2 |
| Бусад биет бус хөрөнгө | 18,000.0 | 18,000.0 | 0.0 | 0.3 |
| **НИЙТ ДҮН** | 5,738,199.7 | 5,963,778.3 | 225,578.6 | 100.0 |

*Эх сурвалж: Бууцагаан сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Үндсэн хөрөнгийн үлдэгдэлд 97.7 хувь ЗДТГ, 2.3 хувь нь ИТХ-ийн хөрөнгө байна.

*Хүснэгт № 9. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| ИТХ | 36,217.0 | 50,881.6 | 14,664.6 | 2.3 |
| ЗДТГ | 5,728,982.7 | 2,136,999.3 | -3,591,983.4 | 97.7 |
| **НИЙТ ДҮН** | **5,765,199.7** | **2,187,880.9** | **-3,577,318.8** | **100.0** |

*Эх сурвалж: Бууцагаан сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд үндсэн хөрөнгө 394,404.8 мянган төгрөгөөр хөрөнгө нэмэгдсэн нь ЗДТГ нь төсвийн хөрөнгөөр 54,254.1 мянга, ИТХ-ын 22,580.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, аймгийн ИТХ-ын даргын 2024.04.03-ны өдрийн "Үндсэн хөрөнгөнд эзэмшигч тогтоох тухай" 25 дугаар захирамж, 2024.11.18-ны 99 дүгээр захирамжаар ЗДТГ-т 298,255.1 мянга, ИТХ-д 19,315.6 мянган төгрөгийн улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн хөрөнгийг орлого авч бүртгэсэн нь голлох нөлөө үзүүлсэн байна.

Мөн аймгийн ИТХ-ын даргын 2024.05.30-ны өдрийн "Хөрөнгө акталж данснаас хасах тухай" 38 дугаар захирамжаар сумын ЗДТГ-ын 146,089.8 мянга, ИТХ-ын 8,373.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, аймгийн ИТХ-ын даргын 2024.02.16-ны өдрийн "Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай" 04 дүгээр захирамжаар сумын ЗДТГ-ын газраас сумын ИТХ-д 14,800.0 мянган төгрөгийн автомашиныг шилжүүлсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 10. Үндсэн хөрөнгийн орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/*

| Нэмэгдсэн | **394,404.8** | Хасагдсан | **169,262.8** |
|---|---|---|---|
| Худалдан авсан | 76,834.1 | Шилжүүлсэн | 14,800.0 |
| Шилжүүлэн авсан | 317,570.7 | Акталсан | 154,462.8 |

*Эх сурвалж: Бууцагаан сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### 3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 2,143.4 мянган төгрөг байсан ба эцсийн үлдэгдэл 4,191.2 мянган төгрөг болж 2,047.8 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 11. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР ДҮН | 2,143.4 | 4,191.2 | 2,047.8 | 100.0 |
| Ажилчидтай холбогдсон өглөг | - | 1,166.2 | 1,166.2 | 27.8 |
| Бараа үйлчилгээний зардлын өглөг | 1,643.4 | 2,150.0 | 506.6 | 51.3 |
| Байгууллагад төлөх өглөг | 500.0 | 875.0 | 375.0 | 20.9 |
| **Дүн** | 2,143.4 | 4,191.2 | 2,047.8 | 100.0 |

*Эх сурвалж: Бууцагаан сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Богино хугацаат өр төлбөр нь 4,191.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд ЗДТГ-ын үлдэгдэл өр байна.

*Хүснэгт № 12. Нийт өр төлбөрийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| ЗДТГ | 2,143.4 | 4,191.2 | 2,047.8 | 100.0 |
| ДҮН | 2,143.4 | 4,191.2 | 2,047.8 | 100.0 |

*Эх сурвалж: Бууцагаан сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 3,006,286.8 мянган төгрөг байсан ба эцсийн үлдэгдэл 3,080,541.5 мянган төгрөг болж, 74,254.7 мянган төгрөгөөр төгрөгөөр өссөн байна.

**ХҮСНЭГТ № 13. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /МЯНГАН ТӨГРӨГ/**

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өссөн+ Буурсан - | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 537,862.8 | 537,862.8 | - | 17.5 |
| Өмч: - төрийн | | | - | - |
| **Хуримтлагдсан үр дүн** | 2,049,096.4 | 2,123,531.1 | 74,434.7 | 68.9 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 419,327.6 | 419,147.6 | (180.0) | 13.6 |
| **Дүн** | 3,006,286.8 | 3,080,541.5 | 74,254.7 | 100.0 |

Эх сурвалж: Бууцагаан сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 74,254.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### 3.7 Орлогын данс

Сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 13/07 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 537,716.0 мянга, хүү торгуулийн орлогыг 45,000.0 мянга, нийт 582,716.0 мянган төгрөгөөр баталсан ба сумын ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 17/12 дугаар тогтоолоор 217,795.0 мянган төгрөгийн орлогыг нэмж тодотгосон байна.

*Хүснэгт №14. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/*

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| Нийт орлого ба тусламжийн дүн | 1,222,536.4 | 1,457,489.1 | (234,952.7) | 119.2 |
| Татварын орлого | 755,373.0 | 917,734.9 | (162,361.9) | 121.5 |
| Орлогын албан татвар | 558,700.0 | 646,607.6 | (87,907.6) | 115.7 |
| ХХОАТ | 558,700.0 | 646,607.6 | (87,907.6) | 115.7 |
| ЦХТА рлого /суутган/ | 385,000.0 | 418,679.2 | (33,679.2) | 108.7 |
| Үйл ажиллагааны орлого | 127,900.0 | 168,488.0 | (40,588.0) | 131.7 |
| Хөрөнгийн орлого | 42,800.0 | 57,130.4 | (14,330.4) | 133.5 |
| Хөрөнгө борлуулсны орлого | 3,000.0 | 2,310.0 | 690.0 | 77.0 |
| Хөрөнгийн албан татвар | 120,705.0 | 101,559.5 | 19,145.5 | 84.1 |
| Үл хөдлөх хөрөнгийн албан татвар | 1,900.0 | 2,011.9 | (111.9) | 105.9 |
| Галт зэвсгийн албан татвар | 2,610.0 | 3,120.0 | (510.0) | 119.5 |
| Малд ногдуулах албан татвар | 116,195.0 | 96,427.6 | 19,767.4 | 83.0 |
| Бусад татвар, төлбөр, хураамж | 20,768.0 | 32,008.2 | (11,240.2) | 154.1 |
| Бусад нийтлэг төлбөр, хураамж | 20,768.0 | 32,008.2 | (11,240.2) | 154.1 |
| Улсын тэмдэгтийн хураамж | 5,000.0 | 10,821.1 | (5,821.1) | 216.4 |
| ТТАМАТөлбөр | 500.0 | 472.1 | 27.9 | 94.4 |
| Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 15,268.0 | 20,715.0 | (5,447.0) | 135.7 |
| Газрын төлбөр | 6,500.0 | 5,438.9 | 1,061.1 | 83.7 |
| Газрын төлбөр | 6,500.0 | 3,938.9 | 2,561.1 | 60.6 |
| Газрын дуудлага худалдааны орлого | - | 1,500.0 | (1,500.0) | |
| Байгалийн нөөц ашигласны төлбөр | 48,700.0 | 132,120.7 | (83,420.7) | 271.3 |
| Ан амьтны нөөц ашигласны төлбөр | 35,360.0 | 118,890.7 | (83,530.7) | 336.2 |
| Ус, рашааны нөөц ашигласны төлбөр | 13,340.0 | 13,230.0 | 110.0 | 99.2 |
| Татварын бус орлого | 467,163.4 | 539,754.2 | (72,590.8) | 115.5 |
| Нийтлэг татварын бус орлого | 107,138.0 | 199,986.6 | (92,848.6) | 186.7 |
| Торгуулийн орлого | 45,000.0 | 138,279.0 | (93,279.0) | 307.3 |
| Төсөвт байгууллагын өөрийн орлого | 62,000.0 | 61,707.6 | 292.4 | 99.5 |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 61,000.0 | 60,366.0 | 634.0 | 99.0 |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000.0 | 1,341.6 | (341.6) | 134.2 |
| Газрын тосны орлого | 138.0 | | 138.0 | - |
| Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 360,025.4 | 339,767.6 | 20,257.8 | 94.4 |
| Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого | 360,025.4 | 339,767.6 | 20,257.8 | 94.4 |

*Эх сурвалж: Бууцагаан сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 121.9 хувь буюу 162,361.9 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Орлогын нэр төрлөөр авч үзвэл цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 33,679.2 мянга, үйл ажиллагааны орлого 40,588.0 мянга, хөрөнгийн орлого 14,330.4 мянга, үл хөдлөх хөрөнгийн албан татварыг 111.9 мянга,

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

галт зэвсгийн албан татвар 510.0 мянга, улсын тэмдэгтийн хураамжийг 5,821.1 мянга, хог хаягдлын хураамж 5,447.0 мянга, газрын дуудлага худалдааны орлогыг 1,500.0 мянга, ан амьтны нөөц ашигласны төлбөрийг 83,530.7 мянга, хүү торгуулийн орлогыг 93,279.0 мянган төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн байна.

Харин хөрөнгө борлуулсны орлого 690.0 мянга, малд ногдох албан татвар 19,767.4 мянга, газрын төлбөрийн орлогыг 2,042.7 мянга, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 27.9 мянга, газрын төлбөр 2,561.1 мянга, ус, рашааны нөөц ашигласны төлбөрийг 110.0 мянган төгрөгөөр тус тус дутуу төвлөрсөн байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогод сумын Засаг даргын Тамгын газар 1,000.0 мянган төгрөгийн орлогыг оруулахаар төлөвлөж 1,341.6 мянган төгрөгийн орлого орлого оруулж 341.6 мянган төгрөгөөр давуулсан байна.

Сум хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн төлөлтөөр тайлант онд 61,000.0 мянган төгрөгийг оруулахаар баталснаас 12,811.8 мянга, Орон нутгийн хөгжлийн сангийн өвс, тэжээлийн орлогоос 46,212.6 мянган төгрөгийн орлого төвлөрсөн байна.

### 3.8 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 73,402, 71602, 71702, 71801, 71802, 72101 гэсэн кодтой 9 хөтөлбөрт зориулан 2,808,245.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж 2,695,395.6 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас 2,139,417.2 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулж 555,978.5 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулсан байна.

*Хүснэгт №15.Төсвийн гүйцэтгэл /мянган төгрөг/*

| Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|
| **Нийт зарлага ба зээлийн дүн** | **2,808,245.0** | **2,695,395.6** | **112,849.4** | **96.0** |
| **70105 Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага** | **188,055.5** | **184,688.1** | **3,367.4** | **98.2** |
| 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал | 168,055.5 | 164,688.1 | 3,367.4 | **98.0** |
| 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал | 500.0 | 500.0 | 0.0 | 100.0 |
| 82201 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх | 19,500.0 | 19,500.0 | 0.0 | 100.0 |
| **70106 Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага** | **1,187,376.1** | **1,170,868.8** | **16,507.3** | **584.6** |
| 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал | 747,717.4 | 746,563.3 | 1,154.1 | 99.8 |
| 80106 Баг хорооны үйл ажиллагааны зардал | 193,824.0 | 193,824.0 | 0.0 | 100.0 |
| 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал | 35,692.3 | 35,629.7 | 62.6 | 99.8 |
| 81102 Орон нутгийн нөөц хөрөнгө | 80,000.0 | 79,963.9 | 36.1 | 100.0 |
| 81701 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардал | 101,504.4 | 86,249.9 | 15,254.5 | 85.0 |
| 82212 хур хог хаягдал, орчны бохирдол | 28,638.0 | 28,638.0 | 0.0 | 100.0 |
| **70503 Орон нутгийн зорилтот орон оруулалт** | **577,724.8** | **555,978.5** | 21,746.3 | 96.2 |
| 80904 Нийгмийн зориулалттай барилга | 101,504.4 | 107,504.4 | -6,000.0 | 105.9 |
| 83401 ОНХС-Итгэлцүүрээр тооцох | 357,502.4 | 352,420.0 | 5,082.4 | 98.6 |
| 73403 ОНХС-ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр | 2,523.0 | 0.0 | 2,523.0 | 0.0 |
| 83405 ОНХС Малын тоо толгойн албан татвар | 116,195.0 | 96,054.1 | 20,140.9 | 82.7 |
| **71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ** | **116,066.7** | **114,059.1** | **2,007.6** | **98.3** |
| 80111 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 116,066.7 | 114,059.1 | 2,007.6 | 98.3 |
| **71702 Соёл урлаг** | **64,361.8** | **61,612.0** | **2,749.8** | **95.7** |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | |
|---|---|---|---|---|
| 80111 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 64,361.8 | 61,612.0 | 2,749.8 | 95.7 |
| **71801 Сургуулийн өмнөх боловсрол** | **114,438.9** | **110,535.3** | **3,903.6** | **96.6** |
| 80111 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 114,438.9 | 110,535.3 | 3,903.6 | 96.6 |
| **71802 Ерөнхий боловсрол** | **499,221.2** | **497,653.8** | **1,567.4** | **99.7** |
| 80111 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 499,221.2 | 497,653.8 | 1,567.4 | 99.7 |
| **72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих** | **61,000.0** | **0.0** | **61,000.0** | **0.0** |
| 82611 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих | 61,000.0 | 0.0 | **61,000.0** | **0.0** |

*Эх сурвалж: Бууцагаан сумын Засаг даргын нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан*

## 3.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.9.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 5 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн бөгөөд сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар 13/07 дугаар тогтоолоор нийт 2,712,495.7 мянган төгрөгийг баталсан ба сумын ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 17/12 дугаар тогтоолоор 163,664.8 мянган төгрөгийг нэмж тодотгосон байна.

*Хүснэгт №16. Төсвийн төлөвлөлт байгууллагаар /мянган төгрөг/*

| Орлогын төрөл | Төсвийн төсөл | Анх батлагдсан төсөв | Зөрүү |
|---|---|---|---|
| Иргэдийн төлөөлөгчдийн хурал | 326,194.6 | 152,007.8 | 174,186.8 |
| Засаг даргын Тамгын газар | 1,652,263.2 | 1,107,706.1 | 544,557.1 |
| Сургууль | 704,820.4 | 463,271.2 | 241,549.2 |
| Бага сургууль | 306,789.2 | 20,450.0 | 286,339.2 |
| Цэцэрлэг | 96,147.0 | 101,688.3 | -5,541.3 |
| Бага цэцэрлэг | 69,418.2 | 5,670.0 | 63,748.2 |
| Эрүүл мэндийн төв | 165,120.9 | 116,066.7 | 49,054.2 |
| Соёлын төв | 97,999.5 | 64,361.8 | 33,637.7 |
| Сум хөгжүүлэх сан | | 86,274.8 | -86,274.8 |
| Орон нутгийн хөгжлийн сан | | 594,999.0 | -594,999.0 |
| **Нийт дүн** | 3,418,753.0 | 2,712,495.7 | 706,257.3 |

*Эх сурвалж: Бууцагаан сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.9.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар 13/07 дугаар тогтоолоор анх 2,712,495.7 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 17/12 дугаар тогтоолоор 163,664.8 мянган төгрөгөөр өсгөж 2,876,160.5 мянган төгрөг болжээ.

Нийт зардлын 360,025.4 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 873,567.6 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 1,145,307.4 мянган төгрөгийг сумын орон нутгийн орлогоос, 45,000.0 мянган төгрөгийг хүү, торгуулийн орлогоос, 1,000.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогоос, 61,000.0 мянган төгрөгийг хоршоо хөгжүүлэх

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

сангийн эргэн төлөлтийн орлогоос, 101,504.4 мянган төгрөгийг ОНХС-ийн өвс, тэжээлийн орлогоос, 406,812.3 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр аймгаас авсан санхүүгийн дэмжлэг болон орон нутгийн орлогоос 2,336,007.6 мянга, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс 339,767.6 мянга, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 1,341.6 мянга, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 12,811.8 мянга, ОНХС-ийн өвс, тэжээлийн орлогоос 46,212.6 мянга нийт 2,736,141.2 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэн 30,444.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт №17. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөг/*

| Байгууллагын нэр | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь | ОН |
|---|---|---|---|---|---|
| ЗДТГ | 1,187,376.1 | 1,170,868.8 | 16,507.3 | 98.6 | 16,848,9 |
| ИТХ | 188,055.5 | 184,688.1 | 3,367.4 | 98.2 | 3,367.4 |
| Соёлын төв | 64,361.8 | 61,612.0 | 2,749.8 | 95.7 | 2,749.8 |
| Сум хөгжүүлэх сан | 86,274.8 | - | 86,274.8 | 0.0 | |
| Сургууль | 465,271.2 | 465,271.2 | - | 100.0 | |
| Бага сургууль | 33,950.0 | 32,382.6 | 1,567.4 | 95.4 | 1,567.4 |
| Цэцэрлэг | 106,688.3 | 103,884.6 | 2,803.7 | 97.4 | 2,803.7 |
| Баянбуур цэцэрлэг | 7,750.6 | 6,650.7 | 1,099.9 | 85.8 | 1,099.9 |
| ЭМТ | 116,066.7 | 114,059.1 | 2,007.6 | 98.3 | 2,007.6 |
| ОНХС | 620,365.5 | 555,978.5 | 64,387.0 | 89.6 | |
| **Нийт дүн** | **2,876,160.5** | **2,695,395.7** | **180,764.8** | **93.7** | **30,444.5** |

*Эх сурвалж: Бууцагаан сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,695,395.7 мянган төгрөг буюу 93.7 хувьтай байгаа нь урсгал зардлыг ЗДТГ-ын 16,848,9 мянга, ИТХ-ын 3,367.4 мянга, тогтмол зардлыг соёлын төв 2,749.8 мянга, бага сургууль 1,567.4 мянга, цэцэрлэг 2,803.7 мянга, Баянбүрд цэцэрлэг 1,099.9 мянга, эрүүл мэндийн төвийн 2,007.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.9.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 25,033.3 мянга, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 39,773.9 мянга нийт 64,807.2 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 38,900.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 3,252.2 мянга, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгт 22,655.1 мянган төгрөгийг тус тус зарцуулж 0.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 18. Нэмэлт санхүүжилтийн дансны судалгаа /мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | ИТХ | ЗДТГ | НИЙТ |
|---|---|---|---|
| **НИЙТ ОРЛОГО** | 1,000.0 | 63,807.2 | 64,807.2 |
| Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,000.0 | 24,033.3 | 25,033.3 |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 39,773.9 | 39,773.9 |
| **НИЙТ ЗАРЛАГА** | 1,000.0 | 63,807.3 | 64,807.3 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | | 3,252.2 | 3,252.2 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,000.0 | 37,900.0 | 38,900.0 |
| Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 22,655.1 | 22,655.1 |
| **Төсөвт төвлөрүүлсэн** | 0.0 | -0.1 | -0.1 |

*Эх сурвалж: Бууцагаан сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Бууцагаан сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгохтой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Батчимэг гүйцэтгэж аудитын менежер М.Алтантуяа, Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар үе шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Бууцагаан сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 1а/25 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Бууцагаан сумын Засаг даргын 1 дүгээр гарын үсгийг Засаг дарга Х.Дагвадорж, 2 дугаар гарын үсгийг санхүү албаны дарга Б.Золзаяа нар зурж байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны нийт батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 65 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв 2,876,160.5 мянган төгрөгөөс 1.2 хувиар буюу 34,514.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

материаллаг байдлын төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 22,434.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон *Төрийн хэмнэлтийн тухай хуулийн* хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан.

## 4.4 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 145 мэдээллээс 137 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 6 мэдээллийг хугацаа хоцорч, 2 мэдээллийг мэдээлэх хугацаа болоогүй байна.

*Хүснэгт 19. Шилэн дансны мэдээлэл*

| д/д | Хугацаа | Төрөл | Мэдээлвэл зохих/удаа | Хугацаанд оруулсан | Хугацаа хоцроосон | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 12 | 12 | 8 | 2 | 2 |
| 2 | Хагас жил | 1 | 1 | 1 | | |
| 3 | Сар бүр | 6 | 72 | 68 | 4 | |
| 4 | Тухай бүр | 5 | 60 | 60 | | |
| | Нийт | 24 | 145 | 137 | 6 | 2 |

## 4.5 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Уг хуулийн хэрэгжилтийг Бууцагаан сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад зөрчил илрээгүй.

## 4.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 393,176.4 мянган төгрөгийн 5 алдаа, зөрчил илэрсэн ба 11,236.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, зөрчлийг арилгах 381,940.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж, 1 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн ба сумын Засаг даргын 2024.04.16-ны өдрийн 1а/73 дугаар албан бичгээр зөвлөмжийн хэрэгжилтийг ирүүлж хэрэгжилтийг санхүүгийн тайлангийн аудитын Fas системд тооцсон байна.

Шийдвэрийн хэрэгжилт дараах байдалтай байна.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ

*Хүснэгт 19* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Биелэгдээгүй | | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 1 | 11,236.0 | 1 | 11,236.0 | | | 100 |
| Албан шаардлага | 2 | 381,940.4 | 2 | 381,940.4 | | | 100 |
| Хариуцлага тооцох албан шаардлага | 1 | 0 | 1 | 0 | | | |
| Зөвлөмж | 1 | 0 | 1 | 0 | | | 100 |
| Нийт | 5 | 393,176.4 | 5 | 393,176.4 | | | 100 |

### 4.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

### 4.8 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд сумын орон нутгийн нөөц хөрөнгөнд 80,000.0 төгрөгөөр баталж 79,963.9 мянган төгрөгийг зарцуулж 36.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Тайлант онд Засаг даргын нөөц хөрөнгөтэй холбоотой зөрчил дутагдал илрээгүй байна.

### 4.9 Аудитын гол асуудал

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бууцагаан сумын Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтийг 92.7 хувьтай дүгнэсэн байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 2,876,160.5 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 2,695,395.7 мянган төгрөгийг зарцуулж 93.7 хувийн биелэлттэй байна.

Орлогын нэр төрлөөр авч үзвэл цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 33,679.2 мянга, үйл ажиллагааны орлого 40,588.0 мянга, хөрөнгийн орлого 14,330.4 мянга, үл хөдлөх хөрөнгийн албан татварыг 111.9 мянга, галт зэвсгийн албан татвар 510.0 мянга, улсын тэмдэгтийн хураамжийг 5,821.1 мянга, хог хаягдлын хураамж 5,447.0 мянга, газрын дуудлага худалдааны орлогыг 1,500.0 мянга, ан амьтны нөөц ашигласны төлбөрийг 83,530.7 мянга, хүү торгуулийн орлогыг 93,279.0 мянган төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн байна.

Харин хөрөнгө борлуулсны орлого 690.0 мянга, малд ногдох албан татвар 19,767.4 мянга, газрын төлбөрийн орлогыг 2,042.7 мянга, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 27.9 мянга, газрын төлбөр 2,561.1 мянга, ус, рашааны нөөц ашигласны төлбөрийг 110.0 мянган төгрөгөөр тус тус дутуу төвлөрсөн байна.

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Бууцагаан сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 2 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 4 байгууллагын санхүүгийн тайлан 4 улсын төсвийн байгууллагын тогтмол зардал нэгтгэгдсэн байна

Төрийн аудитын байгууллагаас Бууцагаан сумын Засаг даргын харьяа 4 байгууллагын санхүүгийн тайланг түүвэр аудитад хамруулан санхүүгийн аудитыг гүйцэтгэсэн байна.

*Хүснэгт №20. Төсвийн шууд захирагчийн аудитын дүн*

| Байгууллагын нэр | Байгууллагын тоо | | | | Аудитын санал дүгнэлтийн төрөл | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Гүйцэтгэсэн | | | Үүнээс | | | |
| | Хамрагдвал зохих | Хамрагдсан | Бие дааж дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Бүгд | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| **ЗДТГ** | 1 | 1 | | 1 | | | | | |
| **ИТХурал** | 1 | 1 | | 1 | | | | | |
| ОНХС | 1 | 1 | | 1 | | | | | |
| **СХС** | 1 | 1 | | 1 | | | | | |
| **НИЙТ ДҮН** | **4** | **4** | | **4** | | **0** | **0** | **0** | **0** |

*Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл*

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 549,705.7 мянган төгрөгийн 20 алдаа, зөрчил илэрснээс 31,370.9 мянган төгрөгийн 7 төлбөрийн акт, 344,151.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 10 албан шаардлага, шилэн дансны хууль зөрчсөнтэй холбоотой 169,758.1 мянган төгрөгийн 2 албан шаардлага өгч ажилласан байна. Хүснэгтээр харуулбал:

*Хүснэгт №21. Төсвийн шууд захирагчийн алдаа зөрчлийн дүн* */мянган төгрөгөөр/*

| Байгууллагын нэр | Нийт алдаа зөрчлийн дүн | | Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Залруулга | | Тогтоосон төлбөрийн акт | | Өгсөн албан шаардлага | | Өгсөн зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн зөрчил | | | | | | | | | | |
| ИТХурал | 2 | 31,526.8 | | | - | - | 2 | 31,526.8 | | |
| ЗДТГ | 10 | 123,440.6 | 1 | 4,425.3 | 5 | 12,816.3 | 4 | 106,199.0 | - | - |
| ОНХСан | 5 | 206,725.6 | | | 1 | 300.0 | 4 | 206,425.6 | | |
| СХС | 1 | 18,254.6 | | | 1 | 18,254.6 | | | | |
| СТА зөрчлийн дүн | 18 | 379,947.6 | 1 | 4,425.3 | 7 | 31,370.9 | 10 | 344,151.4 | - | - |
| СТА-аар шалгасан нийцлийн аудитын асуудал | | | | | | | | | | |
| ЗДТГ | 1 | 156,758.1 | | | | | 1 | 156,758.1 | | |
| ОНХСан | 0 | - | | | | | | | | |
| ИТХурал | 1 | 13,000.0 | | | | | 1 | 13,000.0 | | |
| Нийцлийн аудитын дүн | 2 | 169,758.1 | - | - | - | - | 2 | 169,758.1 | - | - |
| Нийт дүн | 20 | 549,705.7 | 1 | 4,425.3 | 7 | 31,370.9 | 12 | 513,909.5 | 0 | - |

*Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэсэн*

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй зөрчлийг санхүүгийн тайлангийн болон нийцлийн аудиттай холбоотой асуудал гэж ангилан үзсэн бөгөөд санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 379,947.6 мянган төгрөгийн 18 зөрчил, нийцлийн аудиттай холбоотой 169,758.1 мянган төгрөгийн 2 зөрчил тус тус илэрсэн байна.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Хүснэгт 22. Төсвийн шууд захирагчийн зөрчлийн дүн /мянган төгрөгөөр/

| 8 | Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн /мянган төгрөг/ | Алдаа, зөрчлийн шийдвэрлэлт. | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| A | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| Засаг даргын Тамгын газар | | 275,773.4 | | | |
| 1 | Санхүүгийн тайланд түлш, шатах тослох материалын үлдэгдлээр бүртгэсэн шатахуун биетээр байхгүй байна. | 300.00 | Төлбөрийн акт тогтоосон | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Д.Лхагвадорж А.Отгонцэцэг |
| 2 | Иргэдэд өвс, тэжээл зээлээр худалдан авах гэрээгээр зээлээр өвс олгосон ба гэрээнд заасан хугацаанд иргэд өвсний үнийг төлөөгүй байхад санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй, зардлаар бүртгэсэн байна. | 10,615.00 | Төлбөрийн акт тогтоосон | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Д.Лхагвадорж А.Отгонцэцэг |
| 3 | Албан хаагчид илүү цаг олгох тушаал гараагүй байхад 2024 оны 7 дугаар сард Д.Лхагвадоржид 1,068.5 мянга, 12 дугаар сард Г.Энхтүвшин, М.Жаргалсайхан нарт 318.5 мянган төгрөгийн илүү цагийн хөлсийг олгосон байна. | 318.50 | Төлбөрийн акт тогтоосон | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Д.Лхагвадорж А.Отгонцэцэг |
| 4 | Төрийн албан хаагчдад олгосон 2,958.3 мянган төгрөгийн эм боох материалын үнийн 50 хувийг сумын Засаг даргын 2024.04.04-ний өдрийн А/51 дүгээр захирамжаар төсөвт төвлөрүүлэхээр сумын ЭМТ-ийн дарга, сумын ЗДТГ-ын нягтлан бодогч нарт даалгасан байхад эмийн үнийг төвлөрүүлээгүй байна. | 1,479.20 | Төлбөрийн акт тогтоосон | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Д.Лхагвадорж А.Отгонцэцэг |
| 5 | Бууцагаан сум байгуулагдсаны 100 жилийн ойн дансны үлдэгдлийг төсөвт төвлөрүүлээгүй байна. | 103.60 | Төлбөрийн акт тогтоосон | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Д.Лхагвадорж А.Отгонцэцэг |
| 6 | Үндсэн хөрөнгөд өмнөх онуудад бүртгэсэн 71,709.4 мянган төгрөгийн 7 нэр төрлийн хөрөнгийн ашиглах жилийг хасах нэг жилээр оруулснаас элэгдэл бодогдоогүй байна. | 71,709.40 | Албан шаардлага өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Д.Лхагвадорж А.Отгонцэцэг |
| 7 | Албан хаагчдад сумын ойгоор ажилласан илүү цагийг үндэслэлгүйгээр олгосон байна. | 6,032.60 | Албан шаардлага өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Д.Лхагвадорж А.Отгонцэцэг |
| 8 | Тайлант онд худалдан авсан эм тарианаас 3,207.7 мянган төгрөгийн эм тариаг хугацаа дууссан шалтгаанаар устгасан бөгөөд устгах шийдвэрийг эрх бүхий этгээдээр гаргуулаагүй байна. | 3,207.70 | Албан шаардлага өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Д.Лхагвадорж А.Отгонцэцэг |
| 9 | Санхүүгийн тайланд бүртгэлтэй 70 ухна, 2 бяруу, 10 үнээг маллаж байгаа малчинтай гэрээ байгуулаагүй байна. | 25,249.30 | Албан шаардлага өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Д.Лхагвадорж А.Отгонцэцэг |
| 10 | Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст сумын санхүүгийн албаны дарга Бууцагаан сумын 100 жилийн ойтой холбоотой хандивын орлого, түүний зарцуулалтыг мэдээлээгүй, ЗДТГ-ын нягтлан бодогч таван сая төгрөгөөс дээш 45,000.0 мянган төгрөгийн үнийн дүн бүхий орлогын 2 гүйлгээ, 60,848.8 мянган төгрөгийн 10 шийдвэр, 50,909.3 мянган төгрөгийн 8 гэрээг байршуулаагүй байна. | 156,758.10 | Албан шаардлага өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Д.Лхагвадорж А.Отгонцэцэг |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Иргэдийн төлөөлөгчдийн хурал | | 44,526.8 | | | |
| 1 | Төсвийн хөрөнгөөс 11.526.9 мянган төгрөгийг зарцуулж, сумын ИТХ-ын 21 төлөөлөгч нарт бэлэг дурсгалын зүйлсийг олгосон байна. | 11,526.90 | Албан шаардлага өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | М.Сарантуяа А.Отгонцэцэг |
| 2 | Машин тоног төхөөрөмжид бүртгэлтэй 2022.01.10-ны өдөр худалдан авсан 19,999.9 мянган төгрөгийн 21 ширхэг А7 таблет эзэмшигч нарын гарын үсгээр албажаагүй, хөрөнгө тооллогоор тоологдоогүй байна. | 19,999.90 | Албан шаардлага өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | М.Сарантуяа А.Отгонцэцэг |
| 3 | Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 13,000.0 мянган төгрөгийн зардлыг мэдээлээгүй орхигдуулсан байна. | 13,000.00 | Албан шаардлага өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | М.Сарантуяа А.Отгонцэцэг |
| Хоршоо хөгжүүлэх сан | | 18,254.60 | | | |
| 1 | Хоршоо хөгжүүлэх сангаас 2023 онд зээл авсан "Баян байдраг арвижих" нөхөрлөлийн авсан нийт 18.254.644 төгрөгийн зээлийн хугацаа хэтэрсэн байхад арга хэмжээ аваагүй байна. | 18,254.60 | Төлбөрийн акт тогтоосон | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Х.Дагвадорж Д.Нямдолгор |
| Орон нутгийн хөгжлийн сан | | 206,725.6 | | | |
| 1 | "Сү Чо Ба Даймон"д ХХК-тай байгуулсан 38,000,000 төгрөгийн Наадмын талбайн стадион барих ажлын гэрээнд заасан Зургийн үнэ болох 300,000 төгрөгийг суутгаагүй байна. Энэ нь гүйцэтгэгч компанитай байгуулсан 202405241 дугаартай "Наадмын талбайн стадион барих ажлын гэрээ"-ний 8 дугаар зүйл 8.2 дахь заалтыг зөрчсөн байна. | 300.00 | Төлбөрийн акт тогтоосон | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Х.Дагвадорж Д.Нямдолгор |
| 2 | Буцагаан сумын ИТХ-ын 17/12 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах" ажлын хүрээнд хийгдсэн 20,000,000 (Хорин сая) төгрөгийн худалдан авалт нь иргэдээс санал аваагүй байгаа нь Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 4 дүгээр зүйл 4.3.2 заалтыг зөрчсөн байна. | 20,000.00 | Албан шаардлага өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Х.Дагвадорж Д.Нямдолгор |
| 3 | "Соёлын төвийн гэрэлтүүлэг авах" ажлыг 10,000,000 төгрөгөөр баталсан байхад Үүрээр цацрах гэгээ ХХК-тай 12,450,000 төгрөгийн гэрээ хийж, соёлын төвд баталсан бусад арга хэмжээний хэмнэлтээс 2,450,000 төгрөг зарцуулсан байгаа нь Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 4 дүгээр зүйл 4.7.5 , Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйл 41.2.2 заалтуудыг зөрчсөн байна. | 2,450.00 | Албан шаардлага өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Х.Дагвадорж Д.Нямдолгор |
| 4 | Иргэдээс санал аваагүй, ИТХ-ын 17/12 дугаар тогтоолоор баталсан "Сумын баяр наадам"-ын зардалд 99,900,000 төгрөг зарцуулсан байгаа нь "Төсвийн тухай хуулийн 60 дугээр зүйл 60.3.3 дахь заалтыг зөрчсөн байна. | 94,900.00 | Албан шаардлага өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Х.Дагвадорж Д.Нямдолгор |
| 5 | Буцагаан сумын ОНХС-ийн шилэн дансны нэгдсэн цахим системд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 89,075,651 төгрөгийн зарлагын 8 гүйлгээг мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8 дахь заалтуудыг зөрчсөн байна. | 89,075.60 | Албан шаардлага өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Х.Дагвадорж Д.Нямдолгор |
| | Нийт дүн | 545,280.4 | | | |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 26,024.4 мянган төгрөгийн 4 зөрчил илэрснээс, зөрчлийг давтан гаргахгүй байх 26,024.4 мянган төгрөгийн 4 албан шаардлагыг хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлийн 26,024.4 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон 22,434.4 мянган төгрөгийн гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшнээс 3,590.0 мянган төгрөгөөр их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

### 2.2 Албан шаардлага

2.2.1. Сумын төсөвт төвлөрөх татварын орлогоос хөрөнгө борлуулсны орлого 690.0 мянга, малд ногдох албан татвар 19,767.4 мянга, газрын төлбөрийн орлого 2,042.7 мянга, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 27.9 мянга, газрын төлбөр 2,561.1 мянга, ус, рашааны нөөц ашигласны төлбөр 110.0 мянган төгрөгөөр тасарсан зэрэг зөрчлүүд илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8 дахь “Сум, дүүргийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ” гэсэн заалтыг зөрчин, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг үндэслэлтэй төлөвлөж байх, төсөвт бүрэн төвлөрүүлэх албан шаардлагыг өгөв.

2.2.2. Бууцагаан сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт сул байгаагаас нийт 545,280.4 мянган төгрөгийн 19 алдаа, зөрчил илэрснээс 31,370.9 мянган төгрөгийн 7 төлбөрийн акт тогтоож, 513,909.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 12 албан шаардлагыг хүргүүлсэн нь өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлөөс 152,104.0 мянган төгрөг буюу 38.7 хувиар өссөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10 дахь “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, санхүүгийн тайлангийн аудитын “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Харьяа төсвийн байгууллагуудын санхүү, төсвийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, төсвийн сахилга, бат, хариуцлагыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулж өөрийн эрхлэх асуудлын хүрээний дотоод хяналтыг хэрэгжүүлэх албан шаардлагыг хүргүүлэв.

2.2.3. Сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн “Бууцагаан сумын 2024 оны төсөв батлах тухай” 13/07 дугаар тогтоолоор сумын нийт орлогыг 2,713,321.0 мянга, нийт зардлыг 2,712,495.7 мянган төгрөгөөр баталж орлого, зарлагыг 825.3 мянган төгрөгөөр зөрүүтэй баталсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь “жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь*: Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх “төсвийн тогтвортой байдлыг хангасан байх” зарчмын дагуу сумын ИХТ-аар сумын нэгдсэн

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

төсвийг батлахдаа үнэн зөв баталж, зөрчлийн давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлэв.

2.2.4. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн өмнөх оны төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн нэгтгэсэн тайланг ирүүлэхдээ төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр 54.5 дахь хэсэгт заасан хөтөлбөр арга хэмжээ, хүрсэн дүнгийн талаарх бүрэлдэхүүн хэсгээр ирүүлээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь “Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна”, 54.5.4 дэх “Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Сумын ТТЗ-ийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасан бүрэлдэхүүн гаргаж ирүүлэх, зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлэв.

Дээрх албан шаардлагын биелэлтийг нотлох баримтын хамт Төрийн аудитын байгууллагад 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯНАЛТАНД ОРСОН

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ:

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Сумын төсөвт төвлөрөх татварын орлогоос хөрөнгө борлуулсны орлого 690.0 мянга, малд ногдох албан татвар 19,767.4 мянга, газрын төлбөрийн орлого 2,042.7 мянга, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 27.9 мянга, газрын төлбөр 2,561.1 мянга, ус, рашааны нөөц ашигласны төлбөрийг 110.0 мянган төгрөгөөр тасарсан зэрэг зөрчлүүд илэрлээ. | 1 | 25,199.1 | - | - | 1 | 25,199.1 | - | - |
| Бууцагаан сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт сул байгаагаас нийт 545,280.4 мянган төгрөгийн 19 алдаа, зөрчил илэрснээс 31,370.9 мянган төгрөгийн 7 төлбөрийн акт тогтоож, 513,909.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 12 албан шаардлагыг хүргүүлсэн нь өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлөөс 152,104.0 мянган төгрөг буюу 38.7 хувиар өссөн байна. | 1 | - | - | - | 1 | - | - | - |
| Сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн “Бууцагаан сумын 2024 оны төсөв батлах тухай” 13/07 дугаар тогтоолоор сумын нийт орлогыг 2,713,321.0 мянга, нийт зардлыг 2,712,495.7 мянган төгрөгөөр баталж орлого, зарлагыг 825.3 мянган төгрөгөөр зөрүүтэй баталсан байна. | 1 | 825.3 | - | - | 1 | 825.3 | - | - |
| Төсвийн төвлөрүүлэн захирагчийн өмнөх оны төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн нэгтгэсэн тайланг ирүүлэхдээ төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр 54.5 дахь хэсэгт заасан хөтөлбөр арга хэмжээ, хүрсэн дүнгийн талаарх бүрэлдэхүүн хэсгээр ирүүлээгүй зөрчил илэрлээ. | 1 | - | - | - | 1 | - | - | - |
| Дүн | 4 | 26,024.4 | - | - | 4 | 26,024.4 | - | - |

-----------оОо-----------

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 005 ХЯЗГААРЛАГДМАЛ САНГ... ДУГНЭЛТ